

Таньд зориулсан Ертөнцийн Эзэний Захидал

Таны унших үгс бүр үнэн бөгөөд хэрэв та эдгээр үгсийг хүлээж авбал таны амьдрал өөрчлөгдөх болно. Учир нь энэ үгс Ертөнцийн Эзэний зүрх сэтгэлийн илэрхийлэл юм. Тэр бол таны амьдралынхаа турш хайж байсан Аав тань билээ.

Миний Хүү,

Чи намайг таньж мэдэхгүй байж болох ч Би чиний тухай бүгдийг мэднэ... Дуулал 139:1. Би чиний хэзээ сууж, хэзээ босохыг чинь мэднэ... Дуулал 139:2. Амьдралын чинь бүх замуудыг Би мэднэ... Дуулал 139:3. Тэр байтугай үсний чинь ширхэг бүрийг Би мэднэ... Матай 10:29-31. Учир нь чи Миний дүр төрхөөр бүтээгдсэн... Эхлэл 1:27. Чи Миний дотор оршин, амьдарч бас хөдөлдөг... Үйлс 17:28. Учир нь чи Миний үр удам билээ. Би чамайг эхийн чинь хэвлийд бүрэлдэхээс өмнө мэдэж байсан... Иеремиа 1:4-5. Би бүхнийг бүтээхээсээ өмнө чамайг сонгосон юм... Эфэс 1:11-12. Чиний төрөх чинь алдаа байгаагүй... Дуулал 139:15-16. Учир нь, амьдралын чинь бүхий л өдрүүд Миний номонд бичигдсэн байгаа... Дуулал 139:15-16. Чиний төрсөн өдөр хийгээд хаана амьдрахыг чинь хүртэл Би нарийн тооцоолсон... Үйлс 17:26. Чи аймшигтай бөгөөд гайхамшигтай бүтээгдсэн... Дуулал 139:14. Би чамайг эхийн чинь хэвлийд урнаар шаглаж бүрэлдүүлсэн... Дуулал 139:13. Улмаар төрөх өдрийг чинь хүртэл Би чамтай хамт байсан... Дуулал 71:6. Намайг сайн мэдэхгүй хүмүүс чамд намайг буруу танилцуулсан... Иохан 8:41-44. Би хол байдаг ууртай нэгэн биш харин төгс хайрын бүрэн илэрхийлэл юм... 1 Иохан 4:16. Тиймээс ч энэ хайраа чамтай хуваалцах нь Миний хүсэл... 1 Иохан 3:1. Яагаад гэвэл, чи бол Миний хүүхэд бөгөөд Би чиний Аав билээ... 1 Иохан 3:1. Төрсөн аавын чинь хэзээ ч өгч чадахгүй зүйлсийг Би чамд өгөхийг хүсдэг... Матай 7:11. Яагаад гэвэл, Би бол төгс Аав... Матай 5:48. Чиний авдаг сайн бэлэг бүр Надаас ирдэг... Иаков 1:17. Учир нь Би бол хангагч бөгөөд чиний хэрэгцээг Би хангах болно... Матай 6:31-33. Чамд зориулсан миний төлөвлөгөөнүүд үргэлж найдвараар дүүрэн... Иеремиа 29:11. Яагаад гэвэл Би чамайг мөнхийн хайраар хайрласан... Иеремиа 31:3. Чиний тухай Миний бодлууд далайн эрэг дэх элсний ширхэгээс ч олон билээ... Дуулал 139:17-18. Чамайг хараад Би баярлан бахаддаг... Зефаниа 3:17. Чамд сайн сайхныг хийж өгөхөө Би хэзээ ч болихгүй... Иеремиа 32:40. Учир нь чи Миний үнэ цэнэтэй эрдэнэ минь билээ... Египетээс гарсан нь 19:5. Би чамайг босгон байгуулахыг бүх зүрх сэтгэл ба оюун ухаанаараа хүсдэг... Иеремиа 33:3. Хэрэв чи Намайг бүх зүрх сэтгэлээсээ хайх аваас олох болно... Дэд Хууль 4:29. Миний дотор баярла, Би чиний зүрхний чинь хүслийг биелүүлэх болно... Дуулал 37:4. Учир нь тэр хүслүүдийг чинь өгөгч нь Би билээ... Филиппой 2:13. Би чамд төсөөлж буйгаас чинь илүүг өгөх чадвартай... Эфэс 3:20. Учир нь чамайг асар ихээр урамшуулагч нь Би билээ... 2 Тесалоник 2:16-17. Тиймээс зовлонтой үед чинь Би чамайг тайвшруулах болно... 2 Коринф 1:3-4. Эмтэрсэн зүрх сэтгэлтэй үед чинь, Би чамтай ойр байна... Дуулал 34:18. Би чамайг хургаа тэвэрч буй хоньчин шиг зүрх сэтгэлдээ ойр тэвэрдэг... Исаиа 40:11.

Нэгэн өдөр Би чиний нүдэн дэх бүх нулимсыг арчих болно... Илчлэлт 21:3-4. Мөн энэ дэлхий дээр зовж шаналсан шаналал бүрийг чинь авах болно... Илчлэлт 21:4. Учир нь Би чиний Аав бөгөөд Би чамайг өөрийн хүү Есүс шигээ хайрладаг... Иохан 17:23. Чамд зориулсан миний хайр Есүсээр дамжин илэрхийлэгдсэн юм... Иохан 17:26. Есүс намайг бүрэн илэрхийлдэг... Еврей 1:3. Тиймээс ч Би чиний эсрэг биш харин чиний төлөө байдгийг харуулахын тулд Тэр ирсэн юм... Ром 8:31. Би бас чиний гэмийг цагаатгасан... 2 Коринф 5:18-19. Түүний үхэл чамд зориулсан миний хайрын тод илэрхийлэл билээ... 1 Иохан 4:10. Би чиний хайрыг татахын тулд хайртай бүхнээ өгсөн... Ром 8:32. Хэрэв чи миний хайртай хүү Есүсийг хүлээж авах юм бол намайг ч мөн хүлээж авах болно. 1 Иохан 2:23. Тэгээд чамд зориулсан миний хайрыг чамаас дахин юу ч салгаж чадахгүй... Ром 8:38-39. Над руу ир, Би чиний хэзээ ч хараагүй хамгийн том найрыг хийх болно... Луух 15:7. Би үргэлж Аав чинь байсан бөгөөд үргэлж Аав чинь байх болно... Эфэс 3:14-15. Харин... чи Миний хүүхэд байх уу гэдэг асуултыг Би чамд үлдээе. Иохан 1:12-13. Би чамайг хүлээсээр байна... Луух 15:11-32

... Чамд хайртай,

Агуу Хүчирхэг Ертөнцийн Эзэн Аав чинь.